|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Н | $A_1$ | $A_2$ | $A_3$ | $B_1$ | $B_2$ | $C_1$ | Σ | |
| **1** | Боломжит нөлөөлөл | Бүтээн байгууламжийн явцад хөрс эвдрэлд өртөх, зулгарах, устах | -1 | 1 | 2 | 2 | 1 | 1 | 1 | 8 | Бага |
| | | Барилгын материалын тээвэрлэлтийн нөлөөгөөр шороон зам үүсэх | -1 | 1 | 2 | 2 | 1 | 1 | 1 | 8 | Бага |
| | | Ажилчидын түр байршихтай холбоотой хог хаягдал, орчны талхагдал үүсэх | -1 | 1 | 2 | 2 | 1 | 1 | 1 | 8 | Бага |
| **2** | Сөрөг нөлөөлөл | Бүтээн байгууламжийн ажлын явцад талбай бэлтгэх зорилгоор хөрс хуулах, шимт хөрс хадгалах, | -1 | 1 | 2 | 3 | 1 | 1 | 1 | 8 | Дунд |
| | | Төслийн бүтээн байгууламж болон цаашдын үйл ажиллагааны явцад хэврэг бүтэцтэй элсэнцэр харшороон хөрс талхагдалд өртөх | -1 | 1 | 2 | 3 | 1 | 1 | 1 | 8 | Дунд |
| **3** | Хуримтлагдах нөлөөлөл | Төслийн үйл ажиллагаа эхлэх үед жуулчидын хөрс орчны доройтол үүсэх | -1 | 1 | 2 | 2 | 1 | 1 | 1 | 8 | Бага |
| | | Төслийн өдөр тутмын үйл ажиллагаанаас үүдэлтэй хог хаягдлаар хөрс бохирдох, хөрс эвдрэлд өртөх | -1 | 1 | 2 | 2 | 1 | 1 | 1 | 8 | Бага |
| **Дүгнэлт** | | | Дурдсан нөлөөллүүдийн 70% нь бага буюу сул эрсдэлтэй бүсэд багтсан байна. | | | | | | | | |

*Хүснэгт 11. Гадаргын болон газрын доорх усанд нөлөөлөх байдлын үнэлгээний матриц*

| № | Нөлөөллийн хэлбэр | | Нөлөөллийг үнэлэх үзүүлэлт | | | | | | | | Нөлөөллийн түвшин |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | H | $A_1$ | $A_2$ | $A_3$ | $B_1$ | $B_2$ | $C_1$ | Σ | |
| **1** | Гадаргын усны нөөц баялаг | Барилгын ажил | -1 | 1 | 1 | 2 | 2 | 1 | 1 | -8 | Бага |
| | | Аялал жуулчлалын төслийн үйл ажиллагаа | -1 | 1 | 1 | 2 | 2 | 1 | 1 | -8 | Бага |
| **2** | Газрын доорх усны нөөц баялаг | Барилгын ажил | -1 | 1 | 1 | 2 | 1 | 1 | 1 | -7 | Бага |
| | | Аялал жуулчлалын төслийн үйл ажиллагаа | -1 | 1 | 2 | 2 | 1 | 1 | 1 | -8 | Бага |
| **3** | Усны чанарын өөрчлөлт | Барилгын ажил | -1 | 1 | 1 | 2 | 1 | 1 | 1 | -7 | Бага |
| | | Аялал жуулчлалын төслийн үйл ажиллагаа | -1 | 1 | 1 | 3 | 2 | 1 | 1 | -9 | Бага |
| **4** | Усны нөөцийн өөрчлөлт | Барилгын ажил | -1 | 1 | 2 | 1 | 1 | 1 | 1 | -7 | Бага |
| | | Аялал жуулчлалын төслийн үйл ажиллагаа | -1 | 1 | 2 | 2 | 1 | 1 | 1 | -8 | Бага |
| | **Дүгнэлт** | | Дээр дурдсан бүх нөлөөллүүд нь бага зэргийн нөлөөтэй байна.. | | | | | | | | |

*Хүснэгт 12. Ургамлан нөмрөгт нөлөөлөх байдлын үнэлгээний матриц*

| Д/д | Болзошгүй нөлөөлөл | Нөлөөлөлд өртөгдөх талбай, нөлөөллийн хэлбэр | Нөлөөллийн түвшин | | |
|---|---|---|---|---|---|
| | | | их | дунд | бага |
| 1 | Байгалийн ургамалжил устах | Аялал жуулчлалын цогцолбор байгуулах, түүнийг дагалдан бий болох бусад жижиг барилга байгууламжуудыг байгуулах, ашиглах зэргээс | x | - | - |
| 2 | Ургамлын ургах чадварыг алдагдуулах | Машин техникийн хөдөлгөөн, хог хаягдал ба шороо, тоосжилт нь ургамлан бүрхэвч дээр бууж хуримтлагдах | x | - | - |
| 3 | Урт үндэстэй, олон наст ургамалд нөлөөлөх | Бага гүний усны татралт нь гүний усаар тэжээгддэг ургамлын ургалт саарах, мөхөх улмаар ургамал нөмрөгийн доройтолд өртөх | x | - | - |
| 4 | Гадаргын устай холбоотой ургамалжил мөхөх | Хүчтэй аадар бороосны гадаргын урсац, нэл угаагдлаар ургамлан нөмрөг бохирдох, ургамлан бүрхэц багасах, зүйлийн бүрэлдэхүүний тоо цөөрөх, улмаар ургамлан нөмрөг устаж болзошгүй | - | x | - |

*Хүснэгт 13. Амьтны аймагт нөлөөлөх байдлын үнэлгээний матриц*

| № | Нөлөөллийн хэлбэр | Нөлөөлөлд өртөгдөх талбай, нөлөөллийн хэлбэр | Нөлөөллийн түвшин | | |
|---|---|---|---|---|---|
| | | | Их | Дунд | Бага |
| 1 | Амьтад үхэж хорогдох | Өнгөн хөрсийг хуулснаар мэрэгчид, мөлхөгчид болон сээр нуруутан амьтдын амьдрах орчныг сүйтгэх | x | - | - |
| 2 | Зарим зүйлийн шавж, сээр нуруугүйтэн амьтдын тоо буурах | Өнгөн хөрсийг хуулснаар үүдсэн экологийн нөхцөл байдлын өөрчлөлтөөс зарим зүйлийн шавжийн тоо толгой буурах, өсөн нэмэгдэж болзошгүй. | | x | - |
| 3 | Зэрлэг амьтад ойр орчмоос дайжих | Дуу чимээ, гэрэлтүүлэг, тээврийн хэрэглэлийн хөдөлгөөн ба машин техникийн нөлөөгөөр | x | - | - |
| 4 | Мал, амьтан үхэж, үрэгдэх | нүх, суваг шуудуунд мал, амьтан унах | - | - | x |
| 5 | Мал, амьтны бэлчээр хомсдох | Зам барих үйл ажиллагаанаас малын бэлчээр, зэрлэг амьтдын амьдрах талбай хомсдох | - | - | x |
| 6 | Хууль бус ан агнах | Шинээр ирж ажиллаж, суурьших хүмүүс зэрлэг ан амьтдыг хууль бусаар агнах | - | - | x |

# БҮЛЭГ 4. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

## 4.1. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ГОЛ ЗОРИЛТ

Төсөл хэрэгжүүлэгч нь 5 жилийн БОМТ-нд тулгуурласан тухайн жил бүрийн БОМТ-ийг жил бүр боловсруулан батлуулж, хэрэгжилтийг тайлагнан ажиллана. Тухайн жилийн БОМТ-г боловсруулах, түүнийг хэрэгжүүлэх, тайлагнах үйл ажиллагаа нь БОАЖСайдын 2019 оны 10 сарын 29-ны өдөр баталсан А-618 тоот тушаалаар баталсан "Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах, хянан батлах, тайлагнах журам"–ыг баримтална. Монгол Улсын "Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай" хуулийн 9-р зүйлийн 8-р заалт: "Байгаль орчны нөлөөллийн ерөнхий үнэлгээ хийсэн байгууллага төсөл хэрэгжүүлэгчийн тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийн тайланг жил бүрийн 12 дугаар сард багтаан хүлээн авч дараа оны төлөвлөгөө болон түүнийг хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгө, зардлын хэмжээг батална.

## 4.2. ХАМРАХ ХҮРЭЭ

Байгаль орчны менежментийн төлөвлөгөө нь "Эрдэс чулуун хөвөнгийн үйлдвэр"-ийн үйл ажиллагааны үед дагаж мөрдөх эрх зүйн зохицуулалтын дагуу хэрэгжих бөгөөд БОННҮ-ний тайлангийн 1 дүгээр бүлэгт төслийн хамрах хүрээг тодорхойлсон. Баянгол дүүргийн 29-р хорооны нутаг дэвсгэрт үйл ажиллагааг эхлэх үед хүрээлэн буй орчныг хамгаалах, сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх зорилт бүхий тус БОННҮ-ний тайланд тусгасан зөвлөмжүүдийн хүрээнд бүхий л асуудлыг хамрахад БОМТ нь дараах үндсэн 2 хэсгээс бүрдэнэ. *Үүнд:*

- ☑ Төслийн байгаль орчны нөлөөллийн үнэлгээгээр тогтоосон сөрөг нөлөөллөөс зайлсхийх, бууруулах, арилгах арга хэмжээг хэрэгжүүлэх арга замууд, тэдгээрийг хэрэгжүүлэх хугацаа болон шаардагдах хөрөнгө зардлыг тусгасан байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө (БОХТ),
- ☑ Төслийн үйл ажиллагааны улмаас байгаль орчны төлөв байдал, хүний эрүүл мэндэд үзүүлж байгаа орчны болон ажлын байрны нөхцөлийг хянах, шинжилгээ хийх, үр дүнг тайлагнах, хэрэгжүүлэх арга хэлбэр, шаардагдах хөрөнгө зардал, хугацааг тусгасан орчны хяналт-шинжилгээний хөтөлбөр (ОХШХ).

Төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд баримтлах эрх зүйн баримт бичиг болон шаардлагыг нь зайлшгүй хангаж мөрдөх стандартуудыг БОМТ-нд тодорхой тусгаж өгнө. Тухайн жилийн БОМТ боловсруулах, биелэлтийг тайлагнах журамд зааснаар байгаль орчны менежментийн төлөвлөгөө нь дараах агуулгатай байх бөгөөд хийх ажлын зардлыг тус бүрчлэн тооцож төлөвлөнө. *Үүнд:*

- Төслийн байгаль орчны нөлөөллийн үнэлгээгээр тогтоосон сөрөг нөлөөллөөс зайлсхийх, бууруулах, арилгах арга хэмжээг хэрэгжүүлэх арга замууд, тэдгээрийг хэрэгжүүлэх хугацаа болон шаардагдах хөрөнгө зардлыг тусгасан төлөвлөгөө;
- Ногоон байгууламж, мод тарих төлөвлөгөө;
- Үйл ажиллагааны үеийн осол, эрсдэлийн менежмент;

- Үйл ажиллагааны үеийн хог хаягдлын менежмент;
- Төслийн үйл ажиллагааны улмаас байгаль орчны төлөв байдалд үзүүлж байгаа өөрчлөлтийг хянах, шинжилгээ;
- Тухайн жилийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага, зохион байгуулалтын төлөвлөлт;
- БОМТ-г нөлөөллийн бүсийн олон нийт, оршин суугчдад тайлагнах, хэлэлцүүлэх арга хэмжээний төлөвлөлт

***Хүснэгт 14. Байгаль орчны төлөвлөгөөний зардлын задаргаа***

| № | Нийт төлөвлөгөөний зардал | Тухайн жилийн зардал (мян.төг) |
|---|---|---|
| **1** | Сөрөг нөлөөллийг багасгах арга хэмжээний зардал | 1 250.0 |
| **2** | Ногоон байгууламж болон нөхөн сэргээлтийн төлөвлөгөө | 1 790.0 |
| **3** | Осол эрсдэлийн менежментийн зардал | 600.0 |
| **4** | Хог хаягдлын менежментийн төлөвлөгөөний зардал | 1 600.0 |
| **5** | Удирдлага зохион байгуулалтын талаар авах арга хэмжээний зардал | 1 000.0 |
| **6** | Байгаль орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн зардал | 3 100.0 |
| **Нийт зардал** | | **9 340.0** |

### 4.2.1. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө /2025 он/

*Хүснэгт 15. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө*

| Гол болон болзошгүй болон сөрөгнөлөөлөл | Сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах арга хэмжээ | Хэрэгжүүлэх хугацаа, давтамж | Тухайн жилд зарцуулах төсөв (мян.төг) | Нийт зардал (мян.төг) | Баримтлах хууль, журам, Стандарт, аргачлал |
|---|---|---|---|---|---|
| Төслийн үйл ажиллагаанд ашиглагдах тээврийн хэрэгслүүдийн орчны агаарт бий болгох бохирдлыг багасгах үүднээс тэдгээрт засвар үйлчилгээг тогтмол хийх, чанар сайтай шатах тослох материал хэрэглэх, яндан утааны шүүлтүүр тавих, утааны хяналтын хэмжилтийг тогтмол хийлгэж байхаас гадна ашиглалтын хугацаа дууссан тээврийн хэрэгслийг ашиглахгүй байх | | Жилд 1 удаа | **250.0** | **250.0** | MNS 4585:2016 Агаарын чанар. Монголын агаарын чанарын стандарт (MNS)-4585:98, MNS-3384:82, MNS-3383:1982 Агаар мандал. Бохирдлын эх үүсвэр, нэр томьёо, тодорхойлолт |
| Ажлын байранд тоос тархахаас сэргийлж, салхивчийн ерөнхий ба хэсгийн системийг хийх, ажлын үед агаар сэлгэх төхөөрөмжийг зориулалтын дагуу ажиллуулж байх, агаар сэлгэх төхөөрөмжийн ажиллагаанд тогтмол үзлэг хийж эвдэрсэн тохиолдолд бүрэн засвар хийж цэвэрлэж байвал зохино. | | | - | Дотоод төлөвлөлтөд тусгасан | |
| **АГААР ОРЧИН** | | | | | |
| Тээврийн хэрэгслийн явалт, ажилчдын хөлөөр хөрс эвдрэх, ургамал гэмтэх, эвдрэл үүсэхээс гадна шатах тослох материал, хог хаягдал, бохирын шингэн алдагдсанаас хөрсөнд бохирдол үүсэж болзошгүй | Орчныг байнга чийглэж ургамал нөмрөгийг сэргээн сайжруулах зорилгоор бороожуулалтын (шүршүүр) систем бий болгох | Жилд 1 удаа | - | - | Газрын тухай хууль 56-р зүйл-56.2 Хөрс хамгаалах, цөлжилтөөс сэргийлэх тухай хууль 6, 7-р зүйл MNS5850-2019, “Хөрсний чанар, хөрс бохирдуулагч бодис, элементүүдийн зөвшөөрөгдөх дээд хэмжээ MNS5916:2008 Байгаль орчин. Үр шимтэй хөрсийг зайлуулахад тавигдах шаардлага ба хөрсийг ухах хугацаанд түр хадгалах MNS3298:1991 Хөрс. Хөрсний дээж авах MNS6458:2014 Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуй. Химийн хорт болон аюултай бодис, бүтээгдэхүүний агуулах. Агуулахын барилга. БНбД 31-19-10, 2010 |
| | Газар ашиглалт, хөрсний бохирдолд нөлөөлж буй нөлөөлөл байгаа эсэхийг тодорхойлох, БОХШХ-т хамруулах | **БОХШХ-т тусгагдсан** | | | |
| | Төслийн талбайн орчмын хөрсний бохирдлыг тодорхойлох хяналт-шинжилгээ хийх | **БОХШХ-т тусгагдсан** | | | |
| | БОХШХ-ын үр дүнг тодорхойлж биелэлтийн тайланд тусгах, тус үр дүнд үндэслэн стандартаас илүү бохирдолтой талбайн хөрсийг солих, саармагжуулж хаях арга хэмжээг тухайн жилийн байгаль орчны менежмент төлөвлөгөөнд тусгаж хэрэгжүүлж байх | Жилд 1 удаа | **200.0** | **200.0** | |

| Гол болон болзошгүй сөрөг нөлөөлөл | Сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах арга хэмжээ | Хэрэгжүүлэх хугацаа, давтамж | Жилд зарцуулах төсөв (мян.төг) | Нийт зардал (мян.төг) | Баримтлах хууль, журам, стандарт, аргачлал |
|---|---|---|---|---|---|
| **ХӨРС, УРГАМАЛ НӨМРӨГ** | | | | | |
| Ахуйн болон үйлдвэрMNS 0900:2005 Ундны усны эрүүл ахуй, чанарын хяналт MNS 0899:1992 Ус хангамжийн эх үүсвэр сонгоход тавигдах шаардлага хог хаягдал хурын усаар угаагдаж, урсац үүсэх, хөрсний усыг бохирдуулах | Хог хаягдлын цэгийг урсац хөрсөнд нэвчихээргүй болгож засаж янзлах, бетон суурийн хамрах хэмжээг нэмэгдүүлэх | **Хог хаягдлын менежментэд тусгагдсан** | | | MNS0900:2005 Байгаль орчин. Хүний эрүүл мэндийг хамгаалах, аюулгүй байдал, Ундны ус, эрүүл ахуйн шаардлага ба чанарын хяналт MNS4586:1998 Усны байгаль орчны чанар, MNS0899:1992 Ус хангамжийн эх үүсвэрийг сонгох дүрэм ба шаардлага болон эрүүл ахуйн шаардлага MNS0017-1-1-10:1979 Ус ашиглалт, хамгаалалт. Нэр томьёо ба түүний тодорхойлолт MNS4079:1988 Усны чанарын нэр томьёо ба тодорхойлолт |
| | Бохир усны шугам хоолой, бохир усыг урьдчилан цэвэрлэх байгууламжийн гэмтэл, түүхий эдийн ил задгай агуулах, хатуу хаягдлаас үүсэх урсац хөрсний усанд нэвчих, угаалга цэвэрлэгээнээс гарсан бохир усыг ил задгай асгах зэргээр хөрсний усны чанарт нөлөөлөхөөс сэргийлэх | Жил бүр | **300.0** | **300.0** | |
| | Хатуу хог хаягдлын цэгийг тохижуулах | **Хог хаягдлын менежментэд тусгагдсан** | | | |
| **УСАН ОРЧИН** | | | | | |
| Үйлдвэрийн барилгын хийц, инженерийн байгууламжийн төлөвлөлт, гүйцэтгэлийн доголдлоос үүдэн аюул, осол гарах | Үйлдвэрийн барилгын хийц, инженерийн байгууламжийн төлөвлөлт, гүйцэтгэлийн доголдлоос үүдэн аюул, осол гарахаас байнга урьдчилан сэргийлэх арга хэмжээ авах, барилгын бүрэн бүтэн байдалд байнгын хяналт тавих | Үйл ажиллагааны бүхий л үед | **500.0** | **500.0** | MNS 4990:2000. Ажлын байрны эрүүл ахуй ба хөдөлмөр хамгаалал. Ажлын байрны орчин. Эрүүл ахуйн шаардлага MNS5885:2008 Агаар бохирдуулагч бодисуудын хүлээн зөвшөөрөгдсөн концентрац.Техникийн ерөнхий шаардлага MNS 5002:2000 Ажлын |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| Ажилтны хариуцлагагүй үйлдэл, хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааг хангаж ажиллаагүйгээс хүний эрүүл мэндэд нөлөөлөх | Үйлдвэрт ажиллаж буй мэргэжилтэн нь хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааг хангаж ажиллахаас гадна аливаа эрсдэлээс урьдчилан сэргийлсэн бүхий л арга хэмжээг авч ажиллах | Үйл ажиллагааны бүхий л үед | - | Дотоод төлөвлөлтөд тусгасан | байрны эрүүл ахуй ба хөдөлмөр хамгаалал. Дуу чимээний нормд тавигдах ерөнхий шаардлага ба аюулгүй ажиллах аргачлал MNS5003:2000<br>Ажлын байрны эрүүл ахуй ба хөдөлмөр хамгаалал. Дуу чимээ хэмжих ерөнхий шаардлага |
| **СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ НИЙТ ТӨСӨВ** | | | **1 250.0** | **1 250.0 мян.төг** | |

### 4.2.2. Ногоон байгууламж болон нөхөн сэргээлтийн төлөвлөгөө /2025 он/

*Хүснэгт 16. Ногоон байгууламж болон нөхөн сэргээлтийн төлөвлөгөө*

| ОРЧНЫ ТОХИЖИЛТ, НОГООН БАЙГУУЛАМЖ | НӨХӨН СЭРГЭЭЛТ БОЛОН АРГА ХЭМЖЭЭ | АРГА ХЭМЖЭЭНИЙ ЦАР ХҮРЭЭ | НИЙТ ТОО ХЭМЖЭЭ | ХЭРЭГЖҮҮЛЭХ ХУГАЦАА, ДАВТАМЖ | НЭГЖИЙН ҮНЭ (МЯН.ТӨГ) | НИЙТ ЗАРДАЛ (МЯН.ТӨГ | БАРИМТЛАХ ХУУЛЬ, ЖУРАМ, СТАНДАРТ, АРГАЧЛАЛ |
|---|---|---|---|---|---|---|---|
| НОГООН БАЙГУУЛАМЖ | Шар хуайс 1.2-1.5м | Төлөвлөгдсөн талбайд мод бут, тарина | 6 ширхэг | 60.0 | **10.0** | **60.0** | Эвдэрсэн газрыг ургамалжуулах, техникийн ерөнхий шаардлага. - MNS 5918:2023; Цэцэрлэг зүлэг ногоон байгууламж |
| | Голт бор 1.2-1.5м | | | 90.0 | **15.0** | **90.0** | |
| | Хайлаас 0.8.1.0м | | | 60.0 | **10.0** | **60.0** | |
| ТЭР БУМ МОД ҮНДЭСНИЙ ХӨДӨЛГӨӨН | 5 Жилийн хугацаанд | | 100 ширхэг | 1 000.0 | **25.0** | **1 000.0** | МУЗГТ-н дугаар 350 2021 оны 11 дүгээр сарын 17-ны өдөр “ТЭРБУМ МОД” Үндэсний хөдөлгөөний талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээ |
| ХӨРС БЭЛТГЭЖ, МОД СУУЛГАХ НҮХ БЭЛТГЭХ | Хар шороо, элс, бууц зэргийг бэлтгэнэ | | 1 Ажилчин /хүн.цаг/ | 580.0 | **10.0** | **580.0** | Хөрс хамгаалах, цөлжилтөөс сэргийлэх тухай хууль Зүлэгжүүлэх талбай бэлтгэх, үр тарих, арчлах MNS 6260 : 2011 |
| **НОГООН БАЙГУУЛАМЖ БАЙГУУЛАХАД ТӨСӨВЛӨГДСӨН ЗАРДАЛ 1 790.0 МЯН.ТӨГ** | | | | | | | |
| *“Газрын тухай хууль”-ийн 56.6-р зүйл: Хот, тосгоны өнгө үзэмж, эрүүл ахуйн нөхцөлийг сайжруулах, газрыг хамгаалах, нөхөн сэргээх шаардлагын дагуу газар эзэмшигч нь эзэмшилд авсан газрын 10-аас доошгүй хувийг ногоон байгууламжтай байна.* | | | | | | | |

### 4.2.3. Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөө

***Хүснэгт 17. Осол эрсдэлийн менежментийн төлөвлөгөөний зардал***

| Болзошгүй аюул, осол сөрөг нөлөө | Урьдчилан сэргийлэх, хамгаалах арга хэмжээ | Арга хэмжээний цар, хэмжээ | Нэгжийн өртөг | Нийт зардал (мян.төг) | Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж |
|---|---|---|---|---|---|
| Үйлдвэрт осол аваар гарахаас сэргийлэх | Тоног төхөөрөмжид байнгын хяналт тавих | Үйлдвэрийн тоног төхөөрөмжид | Дотоод хяналт, шалгалтаар | | |
| | Ажилтан албан хаагчдын мэдлэг чадварт тогтмол шалгалт, хяналт тавих | Удирдлага зохион байгуулалтаар шийдэх | 2025 он | | |
| | Технологийн доголдлын үед гарах ослоос урьдчилан сэргийлж, ослын үед авах арга хэмжээнүүдийг нөлөөллийн хэлбэр бүрээр төлөвлөн тусгах | Удирдлага зохион байгуулалтын арга хэмжээнд тусгах | 2025 он | | |
| Цаг агаарын үзэгдэл, ажилчдын хариуцлагагүй байдлаас шалтгаалан осол гарах | Цаг агаарын мэдээг байнга авч үйл ажиллагаатайгаа холбон ажиллах, болзошгүй ослоос урьдчилан сэргийлэх гарын авлагатай болох | Төсөл хэрэгжүүлэгчийн удирдах ажилтан албан хаагчдад үүрэг даалгавар өгөх | Удирдлага зохион байгуулалтын арга хэмжээнд тусгагдсан | | |
| | Ажилтан албан хаагчдад сургалт зохион байгуулах, аюулгүй ажиллагааны талаарх мэдээллийг өгч байх, самбартай болох | Үйлдвэрийн үйл ажиллагаануудын үед хэрэгжүүлэх ХХАА-ны гарын авлагатай болох | Удирдлага зохион байгуулалтын арга хэмжээнд тусгагдсан | | |
| | Болзошгүй аюул ослын үед ашиглах багаж хэрэгсэл, холбооны хэрэгсэлтэй болох | Ус, элс шороо, хүрз, цэвэрлэгээний бодис, холбооны хэрэгсэл гэх мэт | - | - | - |
| | Болзошгүй аюул ослын үед ашиглах мөнгөн хуримтлал бүрдүүлэх | | 600.0 | | |
| **Нийт зардал (мян.төг)** | | | **600.0** | | |

### 4.2.4. Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө

“Монгол базальт” ХК нь үйлдвэрийн талбайд хаягдал хөнгөн цагаан агуулсан хоёрдогч түүхий эд бүтээгдэхүүнүүдийг ил задгай ихээр хаясан нь цаашид хөрсний байгалийн унаган төрх алдагдаж хими, физик шинж чанарт өөрчлөлт орох нөлөөллийг үүсгэж болзошгүй байна.

Төсөл хэрэгжүүлэгч нь үйл ажиллагааны үр дүнд үүсэж буй хог хаягдлыг байгаль орчин, хүний эрүүл мэндэд үзүүлэх сөрөг нөлөөллийг байж болох хамгийн бага хэмжээнд байлгах зорилготойгоор ажиллах үүрэгтэй бөгөөд хоёрдогч түүхий эдийг ангилан ялгалтаас үлдэх хаягдлаар үйлдвэрийн талбай болон орчны газрын хөрсийг бохирдуулахгүйн тулд хог хаягдлын түр цэг байгуулан хаягдлыг ангилан ялгах хадгалах шаардлагатай. Энэ талаарх зохих мэдлэгийг ажиллагсдадаа эзэмшүүлж, зааварчилгаа өгч байх шаардлагатай.

Хог хаягдлын менежментийн төлөвлөгөөнд үйлдвэр нь хоёрдогч түүхий эдийг ялган ангилах, хадгалах цэг байгуулах, ахуйн хог хаягдлыг ангилан цуглуулах зориулалтын сав байрлуулж цуглуулах, ажилчдын байрны халаалтын нам даралтын зуухнаас гарах нүүрсний үнсийг хадгалах сав байрлуулах, хог хаягдал, үнсээр бохирдсон үйлдвэрийн талбайг цэвэрлэх, хөрсийг сэргээх ажлуудыг төлөвлөлөө.

***Хүснэгт 18. Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө боловсруулахад ашиглах хүснэгт***

| № | Эх үүсвэрээс гарах хог хаягдлын төрөл | Хог хаягдлын код | Аюулын зэрэглэл | Хэмжээ шингэн-м$^3$/жил, хатуу-тн/жил) | Хадгалах | Устгах | Зайлуулах | Ландфилл хийх | Хоёрдогч түүхий эдэд нийлүүлэх |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| Ахуйн хаягдал | | | | | | | | | |
| 1 | Цаас, картон | Т 01 01 | - | | - | - | | - | + |
| 2 | Шил сав | Т01 02 | - | | - | - | | - | + |
| 3 | Хуванцар сав | Т 01 27 | - | | - | - | | - | + |
| 4 | Төмөр лааз, сав | Т 01 28 | - | | | | | | |
| 5 | Яс | Т 01 29 | - | | - | - | | - | + |
| 6 | Ахуйн холимог хог хаягдал (хоол хүнсний үлдэгдэл, хүнсний ногооны хаягдал г.м) | Т 03 01 | - | | - | - | + | - | - |
| 7 | Ахуйн бохир ус | Т 03 99 | - | | - | - | + | - | - |
| Үйлдвэрлэлийн хаягдал | | | | | | | | | |
| | | | | | | | | | |
| 8 | Хоёрдогч түүхий эдийн ангилан ялгалтаас гарах төмрийн хаягдал, кабель утасны хаягдал | 10 06 99 | - | | + | - | | - | - |
| | | | | | | | | | |

***Хүснэгт 19. Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө***

| Хог хаягдлын ангилал | Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ | Хамрах Хүрээ | Хэмжих нэгж | Нэгжийн зардал, мян. төг | Тоо хэмжээ | Нийт зардал, мян. төг | Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж | Баримтлах эрх зүйн баримт бичиг |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 | 9 |
| **Ахуйн хаягдал** | - Мэдээлэл сурталчилгаа хийх, тэмдэгжүүлэх<br>- Хаягдал зайлуулах гэрээг эрх бүхий этгээдтэй хийх | Төслийнталбай | ш | 500.0 | 2 | **1 000.0** | 2025 онд | - Хог хаягдлын тухай хууль;<br>- БОАЖ сайдын 2017.12.12-ны өдрийн А/349 дугаар тушаалын хавсралт. Эх үүсвэрээс гарах хог хаягдлын кодчилсон жагсаалт, тэдгээрийн зэрэглэл;<br>- MNS 5344:2011 Ахуйн хог хаягдлыг тээвэрлэхэд тавих ерөнхий шаардлага,<br>- Засгийн газрын 2018 оны 116-р тогтоолын 1-р хавсралт. Аюултай хог хаягдлыг түр хадгалах,цуглуулах, тээвэрлэх, дахин боловсруулах, устгах болон бүртгэх, тайлагнах журам, |
| | - Хог хаягдлыг ангилан ялгаж,гэрээт ААН -ээр төслийн талбайгаас тогтмол зөөвөрлүүлэх | Төслийн талбай | тн | 50.0 | 12 | **600.0** | 2025 онд Тогтмол сард 2 удаа | |
| | - Үйлдвэрт буцаан авах хаягдал /Чулуун хөвөнгийн тайрдас, хаягдал болон чулуун хөвөнгийн савалгаа, гялгар уутны хаягдал/ | Бүтээгдэхүүн худалдан авсан хэрэглэгчидээс | кг | Жилд ойролцоогоор 850кг хаягдал хөвөнгийн буцаалт авч үйлдвэрийн эргэлтэд оруулдаг. /Монгол базальт ХК-ийн санаачилсан BASALTCycle хөтөлбөрийн хүрээнд ажиллах.<br>Жилд ойролцоогоор 20кг рулон буюу гялгар уутын хаягдал гардаг ба гялгар уут дахин боловсруулах үйлдвэртэй хамтран ажиллах. | | | 2025 онд | |
| | - Төслийн талбай орчмын эргэнтойронд 100 м зайд цэвэрлэгээ хийх | Төслийн талбай орчимд 100 м | удаа | Гэрээнд заасан дүнгээр | - | Үйл Ажиллагааны зардалд тусгах | 2025 онд | |
| **Аюултай хаягдал** | - Аюултай хог хаягдал устгах эрх, зөвшөөрлийг авах<br>- Мэдээлэл хийх, тэмдэгжүүлэх | Төслийн талбай | удаа | Гэрээнд заасан дүнгээр | - | Үйл ажиллагааны зардалд тусгах | 2025 онд | |
| | - Химийн бодисын сав баглаа боодол, лабораторийн хаягдал | Химийн бодис материал ашиглах байгууламжууд | ш, тн, л | Элемент, Цэцүүх трейд ХХК-д гэрээний дагуу шилжүүлэх. | | | 2025 онд | |
| **Хог хаягдлын менежментийн төлөвлөгөөний нийт төсөв** | | | | | | | | **1 600.0 мян.төг** |

**Хог хаягдлын тухай хуульд заасан эрх үүргэз**

Төсөл хэрэгжүүлэгч нь Хог хаягдлын тухай хуулийн 10 дугаар зүйл. Хог хаягдлын талаар иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын эрх, үүрэгт зааснаар:

✓ 10.1.Иргэн, аж ахуйн нэгж, байгууллага дараах эрх эдэлнэ:

- 10.1.1.хог хаягдлын тухай хууль тогтоомж зөрчсөн этгээдийн талаар төрийн болон нутгийн захиргааны байгууллагад мэдээлэх, хариуцлага хүлээлгэхийг эрх бүхий байгууллага, албан тушаалтнаас шаардах;
- 10.1.2.хог хаягдлын талаар мэргэжлийн байгууллагаас арга зүйн туслалцаа, зөвлөгөө авах.

✓ 10.2.Хог хаягдлын талаар иргэн, аж ахуйн нэгж, байгууллага дараах үүрэг хүлээнэ:

- 10.2.1.энэ хуулийн 9.1.3-т заасан журмын дагуу энгийн хог хаягдлаа ангилан ялгах;
- 10.2.2.энэ хуулийн 15 дугаар зүйлд заасан шаардлагыг хангасан хогийн савтай байх;
- 10.2.3.аж ахуйн нэгж, байгууллага нь хог хаягдал цуглуулах, тээвэрлэх эрх бүхий иргэн, аж ахуйн нэгж, байгууллагатай хог тээврийн үйлчилгээний гэрээ байгуулах;
- 10.2.4.хог хаягдлаа зориулалтын хогийн сав болон цэгт хаях эсхүл хог хаягдал цуглуулж тээвэрлэх эрх бүхий байгууллагад шилжүүлэх;
- 10.2.5.үүссэн аюултай хог хаягдлаа эрх бүхий байгууллагад, эсхүл тогтоосон тусгай цэгт хүлээлгэн өгөх;
- 10.2.6.нийтийг хамарсан цэвэрлэгээ, иргэдийн бүлгээс зохион байгуулсан үйл ажиллагаанд оролцох;
- 10.2.7.хог хаягдлын үйлчилгээний хураамжийг тогтоосон хугацаанд төлөх;
- 10.2.8.хог хаягдлыг бууруулах, ангилах, дахин ашиглах, зүй зохистой хаях дадал зуршлыг хэвшүүлэх;
- 10.2.9.эзэмшлийн барилга, байгууламжийн гадна хана, хашаа, хайсан дээр хог хаягдал болохоор зар сурталчилгаа байршуулахгүй байх;
- 10.2.10.энэ хуулийн 9.4.12-т заасан нийтийн эдэлбэр газрын хог хаягдал, цас, мөсийг цэвэрлэх;
- 10.2.11.барилга барих, буулгах, засварлах үйл ажиллагаанаас гарах хог хаягдлыг цуглуулах, тээвэрлэх, дахин боловсруулах, устгах, булшлах эрх бүхий иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад шилжүүлж, үйлчилгээний хөлсийг хариуцах;
- 10.2.12.хог хаягдлын талаарх сургалтад хамрагдаж, мэдлэгээ дээшлүүлэх;
- 10.2.13.хамгийн боломжит арга технологи, байгаль орчинд ээлтэй арга ажиллагааг нэвтрүүлэх замаар хог хаягдлаас хүний эрүүл мэнд, байгаль орчинд үзүүлэх нөлөөллийг бууруулах;
- 10.2.14.хог хаягдлын талаарх хууль тогтоомж, стандартын шаардлагыг хангаж ажиллах;

- 10.2.15.хог хаягдлын улмаас хүний эрүүл мэнд, байгаль орчинд хохирол учруулсан, учруулж болзошгүй байдал бий болсон тохиолдолд тухайн шатны Засаг дарга болон онцгой байдал, цагдаа, эрүүл мэндийн байгууллагад мэдэгдэх;
- 10.2.16.аж ахуйн нэгж, байгууллага нь байгууллагын ажилтнуудад хог хаягдлын менежментийн талаар сургалт зохион байгуулж, зохих мэдлэгийг эзэмшүүлэх, дадал зуршлыг хэвшүүлэх;
- 10.2.17.үйл ажиллагаанаас үүсэх хог хаягдлыг ангилан ялгах, хог хаягдал цуглуулах, тээвэрлэх, дахин боловсруулах, сэргээн ашиглах, шатаах, устгах эрх бүхий байгууллагад шилжүүлэх, эдгээр үйл ажиллагаатай холбоотой гэрээ байгуулах, гэрээний хэрэгжилтэд хяналт тавих, байгууллагын дотоод болон гадна орчны цэвэрлэгээг хариуцах үүрэг бүхий нэгж, эсхүл ажилтантай байх;
- 10.2.18.аж ахуйн нэгж, байгууллага нь хүний эрүүл мэнд, байгаль орчинд хог хаягдлаас үзүүлэх нөлөөллийг бууруулах шаардлагатай арга хэмжээг авах, аюулгүй ажиллагааг хангах.

✓ 10.3.Иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад хог хаягдалтай холбоотой дараах үйл ажиллагааг хориглоно:

- 10.3.1.хог хаягдлыг дэд бүтцийн шугам хоолойд хаях;
- 10.3.2.нийтийн эдэлбэр газар, ногоон бүс, үерийн далан сувагт хог хаягдал хаях;
- 10.3.3.хог хаягдлыг ил задгай шатаах;
- 10.3.4.гэрийн болон нам даралтын зууханд нийлэг материалтай хог хаягдлыг шатаах;
- 10.3.5.хог хаягдлыг хогийн сав болон тогтоосон цэгээс бусад газарт хаях;
- 10.3.6.аж ахуйн нэгж, байгууллага нь хөрс бохирдуулагч жорлон байгуулах;
- 10.3.7.нийтийн эзэмшлийн эд хөрөнгө дээр зар сурталчилгаа байршуулах, шашны болон зан үйлийн эд зүйлс тавьж хог хаягдал үүсгэх.

✓ 15 дугаар зүйл. Хогийн саванд тавигдах шаардлага

- 15.1.Нийтийн болон эдэлбэр газар байршуулах хогийн сав дараах шаардлагыг хангасан байна:
- 15.1.1.хог хаягдлыг ангилах, ачих, цуглуулах технологид нийцсэн;
- 15.1.2.галд тэсвэртэй материалаар хийгдсэн;
- 15.1.3.хог хаягдал салхиар тархах, хур тунадасны ус хуримтлагдах, шүүрэл ялгарахаас сэргийлсэн.

### 4.2.5. Удирдлага, зохион байгуулалтын талаар авах арга хэмжээ

Төслийн хэрэгжилтийн үед авч хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын асуудал ихээхэн чухал үүрэгтэй юм. Удирдлага зохион байгуулалтын менежментийг дараах чиглэлд хандуулан төлөвлөгөөндөө тусгах нь зүйтэй.

- ✓ Удирдлага, зохион байгуулалтын талаарх арга хэмжээг хариуцан гүйцэтгэх байгаль орчны мэргэжилтэн ажиллуулах
- ✓ Байгаль орчны асуудал хариуцаж ажиллах ажилтан албан хаагч, түүний үүрэг хариуцлага
- ✓ Байгаль орчны чиглэлээр орон нутгийн иргэд, олон нийттэй хамтран ажиллах ажлын чиглэл
- ✓ Ажилтан албан хаагчдын дунд зохион байгуулах сургалт, танилцуулгын ажил, мэдээллийн самбар
- ✓ Хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны чиглэлээр хийгдэх ажил
- ✓ Байгаль орчин хамгааллын чиглэлээр хийгдэх хяналт, шалгалтын хуваарь, бүртгэл хөтлөх, түүнийг хариуцах үүрэг хариуцлагын систем
- ✓ Байгаль орчин хамгааллын чиглэлээр бусад байгууллагатай хамтран ажиллах ажлын төлөвлөгөө, хуваарь
- ✓ Байгаль орчин хамгааллын чиглэлээр хийгдэх ажлын төсөв санхүүгийн зохицуулалт

Удирдлага зохион байгуулалтын чиглэлээр: Төсөл хэрэгжүүлэгч нь жил бүр байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөг мэргэжлийн байгууллагатай хамтран боловсруулж батлуулан, хэрэгжилтийг ханган ажиллах, жилийн эцэст БОМТ-ний хэрэгжилтийг нийслэлийн БОГ-аар дүгнүүлэх, оролцогч, сонирхогч талуудад тайлагнах, хэлэлцүүлэх ажлыг зохион байгуулах, байгаль орчны хуулийн өөрчлөлттэй холбоотойгоор компанийнхаа дотоод дүрэм, журамд өөрчлөлт оруулах, ОБГ, МХГ зэрэг газруудаар станц дээрээ хяналт тавиулж, хамтран ажилчдынхаа дунд галын аюулгүй ажиллагаа, хөдөлмөр хамгааллын сургалтуудыг зохион байгуулах, осол эрсдэлээс хамгаалах ажлыг зохион байгуулах шаардлагатай.

Хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагаа, ажиллагсдын эрүүл мэндийг хамгаалах ажлууд: Төсөл хэрэгжүүлэгч нь жил бүр ажилчдад ажлын байрны онцлог тус бүрд нийцсэн ажлын хувцас хэрэгслийг олгох, хортой нөхцөлд ажилладаг ажилтанд хор саармагжуулах бүтээгдэхүүнийг ажлын байранд тогтмол олгох, жил бүр эрүүл мэндийн төвтэй хамтран нийт ажиллагсдаа эрүүл мэндийн үзлэг шинжилгээнд хамруулан, нарийн мэргэжлийн эмч нараар ажил, мэргэжлийн онцлогоос шалтгаалсан өвчлөлөөс урьдчилан сэргийлэх сургалт, зөвлөгөө өгүүлэх, шаардлагатай тохиолдолд ажилтнуудыг амбулаториор эмчилгээнд хамруулах, машин тоног төхөөрөмж дээр ажиллах аюулгүй ажиллагааны зааварчилгааг байрлуулж, ажилд гарахын өмнө ажиллагсдад аюулгүй ажиллагааны зааварчилгааг өгөх, ажлын байранд яаралтай үед хэрэглэх түргэн тусламжийн багаж хэрэгсэл, эм тариа бэлтгэх ажлуудыг төлөвлөлөө.

***Хүснэгт 20. Байгаль орчны менежментийн хүрээнд хэрэгжүүлэх ажил***

| № | Хэрэгжүүлэх арга хэмжээ | Хугацаа | Зардал, мян.төг | Шаардлага |
|---|---|---|---|---|
| 1. Хуулийн хэрэгжилтийг хангуулах | | | | |
| 1 | БОМТ-д тусгасан байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө, орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлыг тодорхой албан тушаалтанд хариуцуулан үйл | Төслийн нийт хугацаанд | Дотоод зардал | Байгаль орчныг хамгаалах тухай хууль, 31.7 дугаар заалт |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | ажиллагааг зохион байгуулах, дотоод журам тогтоож мөрдөх | | | |
| 2 | Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө, орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээг зохих хугацаанд нь хийж гүйцэтгэх ба биелэлтийг жил бүр дүгнэж, дүнг байгаль орчны хяналтын байгууллагад хүргүүлж байх | Жил бүрийн 11-р сарын 1-ний дотор | - | “Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай” хуулийн 14.1.2-р заалт |
| 3 | Байгаль хамгаалахад иргэдийн оролцоог идэвхжүүлэх, уулзалт зөвлөгөөг жил бүр зохион байгуулах, тэдний санал зөвлөмжийг БОХТ-г хэрэгжүүлэх ажилд тусгах | Жил бүрийн 6-р сард | - | “Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээнд олон нийтийн оролцоог хангах тухай журам” БОНХ-ийн сайдын 2014 оны А-03 тоот тушаалын хавсралт |
| 4 | Хог хаягдлын тухай хуулиар хүлээсэн үүргээ биелүүлэх, хог хаягдлыг аль болох дахин ашиглах, дахин боловсруулах | Жил бүр | - | “Хог хаягдлын тухай” хуулийн шинэчилсэн найруулга, 2017 |
| **2. Ажиллагсдыг чадавхжуулах** | | | | |
| 5 | Ажилчдыг хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны сургалтад тогтмол хамруулах, чадавхжуулах | Жил бүр | Дотоод зардал | “Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай” хуулийн 27.3.4, 28.1.8-р заалт |
| 6 | Орон нутгийн онцгой байдлын хэлтэстэй хамтран ажиллах гэрээ байгуулж, гэнэтийн осол, эрсдэл, түүнээс хамгаалах талаар ажилчдыг сургалтад хамруулах | Жил бүр | Дотоод зардал | “Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуй. Сургалтын зохион байгуулалт үндсэн дүрэм” MNS 4969:2000 |
| 7 | Шаардлагатай үед хэрэглэх иж бүрэн эмийн санг заавартай нь байрлуулах, тогтмол хугацаанд нөхөн сэлбэх | Жил бүр | 1 000.0 | “Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль”-ийн 14-р зүйл |
| 8 | Ажилчдын эрүүл мэндийн үзлэгт тогтмол хамруулах. | Жил бүр | Дотоод зардал | |
| **Нийт зардал** | | | **1 000.0** | |

## БАЙГАЛЬ ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨР

Эрдэс чулуун хөвөнгийн үйлдвэр төслийн үйл ажиллагаанаас байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг тухай бүр илрүүлэх, бууруулах, арилгах зорилгоор байгаль орчны төлөв байдал, шинээр үүсэн бий болсон нөхцөл байдалд ажиглалт, хяналт явуулах үйл ажиллагааны удирдамжийг **“Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр”** гэнэ.

Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр нь Үйлдвэрийн үйл ажиллагааны улмаас байгаль орчны төлөв байдалд гарч байгаа өөрчлөлтийг хянах, шинжилгээ хийх, үр дүнг тайлагнах, түүнийг хэрэгжүүлэх арга хэлбэр, шаардагдах хөрөнгө, зардал, хугацааг тодорхойлох, болзошгүй сөрөг үр дагаврыг хянах, илрүүлэх зорилготой. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрт дараах зүйлсийг тусгасан байх болно. Үүнд:

- ✓ Байгаль орчны бүрэлдэхүүн тус бүрд үзүүлэх нөлөөлөл;
- ✓ Хяналт-шинжилгээ явуулах зайлшгүй шаардлагатай үзүүлэлтүүд;
- ✓ Хяналт-шинжилгээ явуулах төрөл, хэлбэр;
- ✓ Хяналт-шинжилгээ хийх, сорьц авах цэгийн байршил;
- ✓ Хяналт-шинжилгээ явуулах хугацаа, давтамж,
- ✓ Хяналт-шинжилгээ явуулах арга, аргачлал;
- ✓ Хяналт-шинжилгээ явуулахад шаардлагатай техник, тоног төхөөрөмж;
- ✓ Хяналт-шинжилгээний үр дүнг нэгтгэх, тайлагнах арга, хэлбэр зэрэг болно.

Байгаль орчны хяналт шинжилгээний хөтөлбөр нь төслийг хэрэгжүүлэх явцад үүссэн сөрөг нөлөөлөл, түүнийг бууруулах үйл ажиллагаа ямар үр дүнтэй байгааг илтгэх, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний үндэслэлийг боловсруулах, иргэдэд бодит мэдээлэл өгөхөд чухал ач холбогдолтой. Мөн байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөнд тусгасан сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ, тухайн орчинд төслийн үйл ажиллагаанаас шалтгаалан гарсан өөрчлөлтүүдийг тодорхойлох, хянах зорилгоор зайлшгүй хянаж байх үзүүлэлтүүд, түүний тодорхойлолт, хуваарь, баримтлах стандарт, аргачлал, зардлыг тодорхойлон Байгаль орчин ногоон хөгжлийн яамны сайдын 2014 оны04-дүгээр сарын 10 ны өдрийн А-117 дугаар тушаалаар батлагдсан “Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах, хянан батлах, тайлагнах журам”, Байгаль орчин,аялал жуулчлалын сайдын 2019 оны 10 дугаар сарын 29-ний өдрийн А/618 тоот тушаалын хавсралт “Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах, хянан батлах, тайлагнах журам”-д заасны дагуу байгалийн бүрдэл тус бүрээр энэхүү орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийг (ОХШХ) боловсруулав. Дараах хүснэгтэд төслийн хугацаанд жил бүр хийгдэх ОХШХ-ний төлөвлөгөөг гаргав.

***Хүснэгт 21. ОХШХ-ийн төлөвлөгөө***

| Байгаль орчны бүрэлдэхүүн | Хяналт шинжилгээний үзүүлэлт | Охшх-ийн хуваарь | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | 2025 | 2026 | 2027 | 2028 | 2029 |
| | | 5,9, | 5,9, | 5,9, | 5,9, | 5,9, |
| АГААРЫН ЧАНАР | Тодорхой цэг дээрNOx, SO2, PM2.5, PM10, цаг агаарын үзүүлэлт | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ |
| ХӨРСӨН БҮРХЭВЧ | Агрохимийн үзүүлэлтүүд болонхүнд металлын үзүүлэлтүүд | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ |
| УСАН ОРЧИН | Ерөнхий хими, хүнд металл | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ |

*Хүснэгт 22. Үйл ажиллагааны үе шатанд хэрэгжүүлэх байгаль орчны хяналт шинжилгээний хөтөлбөр*

| Хяналт шинжилгээ хийх үзүүлэлтүүд | Хэмжих нэгж | Байршил | Хугацаа, давтамж | Хяналт шинжилгээний ажлын хэмжээ | Нэгж зардал, мян. Төг | Нийт зардал, мян.төг | Мөрдөх стандарт |
|---|---|---|---|---|---|---|---|
| **АГААРЫН ЧАНАР, ДУУ ЧИМЭЭ** | | | | | | | |
| Хүхрийн исэл SO2 Азотын давхар исэл Nox, нийт тоосонцор<br>Орчны агаарт дэгдэмхий органик нэгдлүүдийг тодорхойлох ($PM_{2.5}$, $PM_{10}$, TSP) | мкг/м3 | Мониторингийн цэг<br>1. Үйлдвэрийн хашаан дотроос<br>2. Түүхий эдийн талбай<br>3. Үйлдвэрийн байр дотор<br>4. Химийн агуулахын хажуу цэг | Жилд 2 удаа | 4 цэгт | 100.0 | **800.0** | - MNS 4585:2016 Агаарын чанар.,<br>- MNS 3384:1982 Сорьц авахад тавих ерөнхий шаардлага,<br>- MNS 17.2.5.11 Агаар дахь хүхэрлэг хийн хэмжээг тодорхойлох фотоколориметрийн арга,<br>- MNS 17.5.1.21:1992 Автотээврийн хэрэгслийн дуу чимээ. Дуу чимээний хүлцэх түвшин хэмжих арга |
| Орчны дуу шуугианы түвшин | дБА | 1. Үйлдвэрийн гадаад орчин<br>2. Үйлдвэрийн дотоод орчин | Жилд 2 удаа | 2 цэгт | 150.0 | **600.0** | |
| **ХӨРСӨН БҮРХЭВЧ** | | | | | | | |
| Хөрсний химийн үзүүлэлтүүд<br>Механик бүрэлдэхүүн<br>Хүнд металлууд | мг/кг | Мониторингийн цэг<br>1. Үйлдвэрийн хашаан дотроос<br>2. Түүхий эдийн талбай<br>3. Үйлдвэрийн байр дотор<br>4. Химийн агуулахын хажуу цэг | Жилд 2 удаа | 4 цэгт | 150.0 | **1 200.0** | - MNS 5850:2019 Хөрсний чанар. агуулагдах бохирдуулах бодисын зөвшөөрөгдөх дээд хэмжээ<br>- MNS 3307:1991, MNS3308:1991 хөрс, хөрсний химийн элементүүдийн нийт хэмжээг тодорхойлох<br>- MNS3310:1991 хөрс, хөрсний агрохимийн үзүүлэлтийг тодорхойлох арга |
| **УСАН ОРЧИН** | | | | | | | |
| Ерөнхий химии болон нянгийн бохирдол | мг-экв/л м | 1. Унд ахуйн ус<br>2. Ахуйн сувгийн оролтын ус | Жилд 2 удаа | 2 цэг | 125.0 | **500.0** | - MNS (ISO) 4867:1999 Усны чанар. Дээжийг боловсруулах, хадгалах зөвлөмж<br>- MNS 4586:1998 Усан орчны чанарын үзүүлэлт. Ерөнхий шаардлага<br>- MNS 0900 : 2018 Ундны ус. Эрүүл ахуйн шаардлага, түүнд тавих хяналт Элемент тус бүрийн аргын стандартаар шинжилж, үр дүнг "Усан орчны чанарын үзүүлэлт. Ерөнхий шаардлага |
| **ХЯНАЛТ МОНИТОРИНГИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ 1 ЖИЛИЙН ТӨСӨВ 3 100.0 МЯН.ТӨГРӨГ** | | | | | | | |

## 4.3. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫГ ХАМГААЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙГ НӨЛӨӨЛЛИЙН БҮСИЙН ОРШИН СУУГЧДАД ТАЙЛАГНАХ ТӨЛӨВЛӨГӨӨ

Төсөл хэрэгжүүлэгч нь Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2019 оны 10 дугаар сарын 29-ний өдрийн А/618 тоот тушаалын хавсралт Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах, Хянан батлах, тайлагнах журмын дагуу тухайн жилийн БОМТ-г боловсруулж батлуулах ба БОМТ-ний биелэлтийг тайлагнах үүргийг хүлээнэ.

Төсөл хэрэгжүүлэгч нь Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2019 оны 10 дугаар сарын 29-ний өдрийн А/618 тоот тушаалын хавсралт Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах, Хянан батлах, тайлагнах журмын 2.2-т заасны дагуу 2025 оны БОМТ төлөвлөгөөг Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээ үнэлгээний ажлын үр дүнгээр боловсруулсан байгаль орчны менежментийн төлөвлөгөөг үнэлгээний мэргэжлийн зөвлөл хэлэлцэн баталснаас хойш төсөл хэрэгжүүлэгч 1 сарын дотор байгаль орчны менежментийн төлөвлөгөөгөө боловсруулан ерөнхий үнэлгээ хийсэн байгууллагад батлуулахаар хүргүүлнэ.

Төсөл хэрэгжүүлэгч тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг ханган биелүүлж түүний үр дүнг тусгасан биелэлтийн тайланг 11 дүгээр сарын 01-ний дотор дээр дурдсан журмын 3-р хавсралтын дагуу гаргаж, харьяалагдах аймгийн байгаль орчны газарт 3-аас доошгүй хэвлэмэл хувь болон цахим хэлбэрээр хүргүүлнэ.

Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуулийн 9.8-д заасны дагуу төсөлд ерөнхий үнэлгээ хийсэн байгууллага тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийн тайланг хүлээн авч, түүнд хийсэн ажлын хэсгийн дүгнэлтийг үндэслэн биелэлтийг хянаж, дараагийн жилд хэрэгжүүлэх байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хянаж батална.

Төсөл хэрэгжүүлэгч нь байгаль орчныг хамгаалах хууль тогтоомж, батлагдсан байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээгээр тодорхойлсон сөрөг нөлөөг бууруулах, арилгах арга хэмжээний зөвлөмж, байгаль орчны менежментийн төлөвлөгөөг үндэслэн жил бүрийн 12 дугаар сард багтаан дараа оны тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг боловсруулна.